**СЭЛЭНГЭ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2018 оны 09 сарын 20 өдөр Дугаар 84 Сүхбаатар сум

"Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө" батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 "з", Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн "Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Аймгийн "Цөлжилттэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд шаардагдах хөрөнгийг жил бүр улс, орон нутгийн төсөвт тусган, хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

ДАРГА Г.БЯМБАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны 09 дүгээр сарын
20-ны өдрийн 84 дүгээр тогтоолын хавсралт

ТТС7446 9055363

# ЦӨЛЖИЛТТЭЙ ТЭМЦЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Зорилго | | Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулах, газрын доройтлоос урьдчилан сэргийлэх, замаар байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, цөлжилтөд өртсөн нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд оршино. | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Үр нөлөө шалгуур үзүүлэлт | | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжиж хугацаа |
| № | Үйл ажиллагааны чиглэл | | | | | |
| Тэргүүлэх чиглэл 1. Чадавхийг бэхжүүлэх | | | | | | |
| 1.1 “Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн үндсэн зорилт, арга хэмжээг салбарын болон орон нутгийн бодлого, хөтөлбөр, төсөвт тусган үр дүнтэй хэрэгжүүлж тайлагнана | | | | | | |
| 1.1 | Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх | Хамтын ажиллагаа | Хөтөлбөрийг хэрэгжилт хангагдсан байна | АЗДТГ | БОАЖГ<br>ХХААГ<br>ГХБХБГ<br>УЦУОШГ | 2018-2022 |
| 1.2 Цөлжилттэй тэмцэх үндэсний хөтлөбөрийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэр, техник, технолгийн нөөцийг бүрдүүлэх | | | | | | |
| 1.2.1 | Цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах | Төсөв батлагдсан байх | Цөлжилттэй тэмцэх арга хэмжээнд төсөв батлагдсан байна | АЗДТГ | БОАЖГ<br>ХХААГ<br>ГХХБГ | 2018-2022 |
| 1.3 Боловсон хүчний чадавхийг сайжруулах | | | | | | |
| 1.3.1 | Боловсон хүчний чадавхийг сайжруулах сургалтыг 3-аас доошгүй удаа зохион байгуулах | Сургалт | 3 удаа сургалт зохион байгуулсан байна. | АЗДТГ | БОАЖГ<br>ХХААГ<br>ГХХБГ | 2018-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1.3.2 | Цөлжилттэй тэмцэх уламжлалт мэдлэг, дэвшилтэт технологи, арга барилыг иргэд, олон нийтэд дэлгэрүүлэх, сурталчлах | Иргэдийн олж авсан мэдлэг | Олон нийтэд сурталчилж ажилласан байна. | АЗДТГ БОАЖГ | ХХААГ ГХБХБГ УЦУОШГ | 2018-2022 |
| 1.3.3 | Цөлжилттэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй ТББ, нөхөрлөл, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих | Цөлжилтийг сааруулах ажил хийгдсэн байх | ТББ нөхөрлөлийн цөлжилттэй тэмцэх чиглэлээр гүйцэтгэх үйл ажиллагаа сайжирсан байна. | АЗДТГ | БОАЖГ ХХААГ УЦУОШГ | 2018-2022 |
| Тэргүүлэх чиглэл 2. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох | | | | | | |
| 2.1 | Батлагдсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах зорилгоор хэвлэн түгээх, сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах | Хууль тогтоомжийн сурталчилгаа | Хууль тогтоомжийг сурталчлах ажил хийгдсэн байна. | АЗДТГ | БОАЖГ ХХААГ УЦУОШГ | 2018-2022 |
| Тэргүүлэх чиглэл 3. Шинжлэх ухаан, технологийн мэдлэгийн хүрээг өргөжүүлэх | | | | | | |
| 3.1 судалгаа шинжилгээний ажлг төлөвлөж хэрэгжүүлэх | | | | | | |
| 3.1.1 | Цөлжилтийн чиглэлээр хийх судалгаа шинжилгээний ажлыг эрдэм шинжилгээний байгууллага, хүрээлэнтэй хамтран гүйцэтгэх | Цөлжилтийн судалгаа | Цөлжсөн газар нутаг тодорхой болно | АЗДТГ | БОАЖГ УЦУОШГ ЭШБ | 2018-2022 |
| Тэргүүлэх чиглэл 4.Сурталчилгаа оролцоог нэмэгдүүлэх, боловсролыг дэмжих | | | | | | |
| 4.1 | Байгаль хамгаалах уламжлалт зан үйл, ёс заншил, байгаль хамгаалах арга замын талаар сургалт сурталчилгааны ажлыг хэрэгжүүлэх | Сурталчилгаа | Байгаль хамгаалах уламжлалт | АЗДТГ | БОАЖГ ХХААГ УЦУОШГ | 2018-2022 |
| 4.2 | “Цөлжилттийг бууруулах Олон улсын өдөр”-ийг иргэд, олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээг зохион байгуулах | Олон нийтэд хүргэх мэдлэг | Олон нийтэд мэдээлэл хүргэсэн байна | АЗДТГ | БОАЖГ ХХААГ УЦУОШГ | 2018-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.3 | Цөлжилттэй тэмцэх, цөлжилтийг сааруулахад идэвх санаачлагатай ажиллаж байгаа иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагыг урамшуулан дэмжих, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах | Урамшуулал | Идэвхтэй ажилласан иргэдийн үйл ажиллагааг нь олон нийтэд сурталчилсан байна. | АЗДТГ | БОАЖГ<br>ХХААГ<br>УЦУОШГ<br>Сумын ЗДТГ | 2018-2022 |
| 4.4 | Байгальд ээлтэй байгаль орчны чиглэлээр сургалт явуулдаг тусгай сургалттай эко-сургуулиудын үйл ажиллагааг дэмжих | Эко-сургууль | Эко-сургуулиудын тоо нэмэгдсэн байх | АЗДТГ | БСГ<br>БОАЖГ | 2018-2022 |
| 4.5 | Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дэргэд сургалт, сурталчилгааны төв байгуулахад дэмжлэг үзүүлэх | Байгаль орчны сургалт, сурталчилгаа явуулах орчин бүрдэнэ. | Сургалтын төв бий болсон байна. | АЗДТГ | Төсөл хөтөлбөр<br>Улсын төсөв | 2018-2022 |
| 4.6 | Аймаг, бүс сумын түвшинд газрын эзэмшил, ашиглалт, хамгаалалт, эрх зүйн мэдээллийн санг бий болгоно. | Мэдээллийн сан бий болсон байна. | Цөлжилтийн явц орчны өөрчлөлтийг хянах, тогтоох урьдчилан сэргийлэх талаар иргэдэд мэдээлэл хүрсэн байна. | АЗДТГ | БОАЖГ<br>Сумын ЗДТГ<br>ХХААГ | 2018-2022 |
| Тэргүүлэх чиглэл 5. Орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх бодит арга хэмжээг дэмжих, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх | | | | | | |
| 5.1 | Хот суурин газрыг элсний нүүлтээс хамгаалах, ногоон бүс байгуулах, технологийн шийдлийг олж тогтоох арга хэмжээг хэрэгжүүлэх | Ногоон бүс байгуулсан байна | Элс тогтворжиж элсний нүүлтийг сааруулсан байна. | АЗДТГ | Сумын ЗДТГ | 2018-2022 |
| 5.2 | Цөлжилт хүчтэй илэрсэн сумдыг сонгож, цөлжилттэй тэмцэх загвар сум бий болгоход олон улсын байгууллагуудын анхаарлыг хандуулах | Загвар сум | 1 загвар сум бий болсон байна | АЗДТГ | БОАЖГ<br>ХХААГ<br>ГХХБГ | 2018-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.3 | Хөрсийг элэгдэл, эвдрэлээ хамгаалах, доройтлыг бууруулах арга технологи нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, иргэдэд санхүүгийн дэмжлэг урамшуулал олгох арга хэмжээг хэрэгжүүлэх | Урамшуулал олгосон байна | Хөрсний элэгдэл эвдрэл буурсан байна. | АЗДТГ | ХХААГ | 2018-2022 |
| 5.4 | Булаг шанд хамгаалах, тохижуулах талаар бодит үйл ажиллагаа явуулж буй иргэд, нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | Булаг шанд хамгаалагдсан байна. | Булаг шандыг хамгаалсан иргэд, 2-4 нөхөрлөлийг дэмжсэн байна | АЗДТГ | БОАЖГ | 2018-2022 |
| 5.5 | Мод сөөг тарих, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажилд иргэдийг татан оролцуулах | Нөхөн сэргээлтийн ажил | Нөхөн сэргээх ажилд иргэдийн оролцоо нэмэгдсэн байна. | С ЗДТГ<br>АЗДТГ | БОАЖГ | 2018-2022 |
| 5.6 | Байгальд ээлтэй эрчим хүчний эх үүсвэрийн хэрэглээг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээг хэрэгжүүлснээр гандуу бүс нутгийн мод, бут сөөгийг түлшний зориулалтаар ашиглахыг багасгах, хязгаарлах | Байгаль ээлтэй эрчим хүчний үүсвэр | Байгаль ээлтэй эрчим хүчний үүсвэр нэмэгдэж, мод, бут сөөгийг түлшний зориулалтаар ашигалах нь буурсан байна. | АЗДТГ | БОАЖГ | 2018-2022 |
| 5.7 | Уур амьсгал, ургамал хөрсний болон усны нөөц хүртээмжээс хамааруулан ойн зурвасны бүтэц, загварыг бий болгох. | Ойн зурвасны бүтэц, загварыг бий болгох | Ойн зурвасны бүтэц, загварыг бий болгосон байна. | АЗДТГ | БОАЖГ | 2018-2022 |
| 5.8 | Ургах чадвартай ургамлын төрөл зүйлийг сонгон цөлжилтийг саруулах | Ургах чадвартай ургамлын төрөл зүйлийг сонгох | Ургах чадвартай ургамлын төрөл зүйлийг сонгон тарималжуулсан байна. | АЗДТГ | БОАЖГ | 2018-2022 |
| 5.9 | Тариалангийн талбайг хамгаалах зорилгоор талбайн гадуур гүн суваг шуудуу татахыг хориглох, ухсан газрыг нөхөн сэргээх. | Тариалангийн талбайг хамгаалах зорилгоор талбайн гадуур гүн суваг шуудуу татсан газрыг тогтоох. | Нөхөн сэргээлт хийгдсэн байна | АЗДТГ | БОАЖГ<br>Сумын ЗДТГ<br>ХХААГ | 2018-2022 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 5.10 | Ус хуримтлуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлэх | Ус хуримтлуулах дэвшилтэт технологийг судлан нэвтрүүлэх. | Ус хуримтлуулах дэвшилтэт технологийг нэвтрүүлсэн байна | АЗДТГ | БОАЖГ Сумын ЗДТГ ХХААГ | 2018-2022 |
| 5.11 | Уул уурхай, хөдөө аж ахуйд хэмнэлттэй ус ашиглалтын аргуудыг нэвтрүүлэх | Шинэлэг аргуудыг нэвтрүүлсэн байна | Уул уурхай, хөдөө аж ахуйд хэмнэлттэй ус ашиглалтын аргуудыг нэвтрүүлсэн байна. | АЗДТГ | БОАЖГ Сумын ЗДТГ ХХААГ | 2018-2022 |
| 5.12 | Ойжуулалтад хэрэглэгдэх технологийг судлан нэвтрүүлэх | Технологийг судлан нэвтрүүлсэн байна | Ойжуулалтанд хэрэглэгдэх технологийг судлан нэвтрүүлж жишиг ойг ойжуулсан байна. | АЗДТГ | БОАЖГ Сумын ЗДТГ ХХААГ | 2018-2022 |

Аймгийн Засаг даргын тамгын газар